



ДУНДГОВЬ АЙМАГ
ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 17 өдөр

Дугаар А/37

Санхүүцлэл

Уламжлалт эмнэлгийн тоног төхөөрөмж
нийлүүлэх гэрээ байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.2, 59.1.11 дэх заалт, Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалын хавсралт "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.4.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын Уламжлалт эмнэлгийн тоног төхөөрөмж нийлүүлэх гэрээг "Аюур Мед Дэвшил ХХК"-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлсүгэй.
2. Дээрх ажилтай холбогдон гарах зардал 19,000,000 (арван есөн сая) төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангаас зарцуулахыг нягтлан бодогч (Т.Энхбат)-д зөвшөөрсүгэй.
3. Уг ажилд холбоотой гарсан зардалд хяналт тавин ажиллахыг Эрүүл мэндийн төвийн дарга (Э.Насандэлгэр)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ О.БАЗАРРАГЧАА



4823020073